

Энэхүү TMT-ийн орчуулгыг 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн Англи хэл дээрх хувилбарт үндэслэн хийв.



Төслийн Мэдээллийн Тайлан

Төслийн Мэдээллийн Тайлан (TMT) – д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг. TMT нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай илтгэдэг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба нэмэлт мэдээллийг бэлэн болсон хойно нь нэмж оруулдаг. Хэрэгжихээр төлөвлөгдсөн төслийн талаарх мэдээлэл урьдчилсан байдлаар байгаа бөгөөд илтгэх шинж чанартай.

TMT-г үүсгэсэн огноо

–

TMT-г шинэчилсэн

2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Төслийн нэр

Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор Хаан банкинд олгож буй зээл

Зээлдэгч/Equity Investment Name

–

Улс

Монгол Улс

Төсөл/Хөтөлбөрийн дугаар

47934-001

Статус

Батлагдсан

Газар зүйн байршил

–

Аливаа орны хөтөлбөр, түншлэлийн стратеги боловсруулах, аливаа төслийг санхүүжүүлэх болон энэхүү баримт бичигт тодорхой газар нутаг, газар зүйн нутаг дэвсгэрийг нэрлэхдээ Азийн Хөгжлийн Банк тухайн газар нутаг, нутаг дэвсгэрийн хууль эрх зүйн статусын талаар аливаа дүгнэлт хийх зорилго агуулдаггүй болно.

Салбар

Санхүү

Дэд салбар

Жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд олгох санхүүжилт болон зээл

Стратегийн зорилго

Байгальд халгүй тогтвортой хөгжил (БХТХ)
Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт (ЭЗХӨ)
Бүс нутгийн интеграцчилал (БНИ)

Өөрчлөлтийг авчрах хүчин зүйлс

Жендэрийн тэгш байдал болон бодлого, үйл ажиллагаанд жендэрийг тусгах (GEM)
Засаглал ба чадавхийг бэхжүүлэх (GCD)
Мэдлэгийн шийдлүүд (KNS)
Түншлэлүүд (PAR)
Хувийн хэвшлийн хөгжил (PSD)

Бодлого, үйл ажиллагаанд жендэрийг тусгах талаарх ангилал

3 дугаар ангилал: Жендэрийн зарим элементүүд (ЖЗЭ)

Төслийн спонсор

Хаан банк

■ Санхүүжилт

| Туслалцааны төрөл ба хэлбэр | Батламжийн дугаар | Санхүүжилтийн эх үүсвэр | Батлагдсан үнийн дүн (мянган ам.доллар) |
|-----------------------------|-------------------|-------------------------|---|
| Хувийн хэвшил | 214/3136 | LIBOR –д суурилсан зээл | 40,000 ам.доллар |
| НИЙТ | | | – |

■ Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй

| | |
|--|--|
| Байгаль орчины ангилалд багтсан | Environmental Aspects |
| Байгаль орчины FI ангилалд орсон | Classified FI environment |
| Албадан нүүлгэн шилжүүлэлт | Involuntary Resettlement |
| Албадан нүүлгэн шилжүүлэлтийн хувьд “С” ангилалд багтсан | Category C for involuntary resettlement |
| Нутгийн уугуул иргэд | Indigenous Peoples |
| Нутгийн уугуул иргэдийн хамгааллын “С” ангилалд багтсан | Category C for indigenous peoples safeguards |

■ Оролцогч талуудтай харилцах, тэдний оролцоо ба хэлэлцүүлэг

Төсөл бэлтгэх явцад

–

Төсөл хэрэгжих явцад

–

■ Тодорхойлолт

Бичил болон жижиг, дунд аж ахуйн нэгжүүд (БЖДААН)-д санхүүжилт олгох зорилгоор Хаан банкинд 40 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээл олгож байна. БЖДААН нь Монгол Улсын ДНБ-ий 70 хувийг хувийг бүрдүүлдэг бөгөөд нийт ажиллах хүчний тэн хагас нь эдгээр аж ахуйн нэгжүүдэд ажилладаг. Иймээс БЖДААН нь Монгол Улсын эдийн засгийг амжилттай хөгжүүлэхэд болон эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал хувь нэмэртэй юм. Монгол Улс өргөн уудам газар нутагтайн улмаас газар зүйн хувьд банкны салбарын тархалтаар дэлхийн хамгийн доогуур улсуудын нэгт орж байна. Тухайлбал нэг хавтгай дөрвөлжин километр газар нутагт 0.67 салбар ногддог. Иймд БЖДААН-ийн хувьд санхүүгийн хүртээмж нь томоохон асуудал байсаар ирсэн. Уг зээл нь БЖДААН-ийн салбарын өрсөлдөөнтэй бөгөөд хөгжингүй болгох Засгийн газрын бодлогыг хөхиүлэн дэмжиж байна. Хаан банк нь зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зах зээлд эзлэх хэмжээнийхээ хувьд Монгол Улсын хамгийн том арилжааны банк бөгөөд тус банкнаас олгож буй зээл, харилцах, халагаламж нь 2013 оны байдлаар нийт зах зээлийн 23 болон 26 хувийг тус тус эзэлж байв. 2013 оны байдлаар Хаан банк нь 528 салбар тооцооны төв болон 335 АТМ-тэй үйл ажиллагаа явуулж байсан нь тус банкныг салбар нэгжийн хүртээмжийн хувьд мөн тэргүүлэх банк болгож байна. Хаан банкны зээлийн багц

2013 оны 12 дугаар сарын байдлаар 1.5 тэрбум ам.доллар байснаас 49 хувь нь хувь хүн, иргэдэд, 16 хувь нь худалдаа, 10 хувь нь барилга угсралт, 3 хувь нь хөдөө аж ахуй, 22 хувь нь бусад салбарт тус тус олгогджээ. 2013 оны байдлаар банкны нийт актив 2.9 тэрбум ам.доллар байв. Тус банкны зээлийн багц 2013 оны сүүлчээр 25-30 хувиар өсч, 2015 онд 22 хувиар буурна хэмээн тооцоолж байгаа бөгөөд нийт өсөлтийн 30-40 хувь нь БЖДАН-үүдэд чиглэсэн зээлд ногдож байна. Банкны нийт орлого 2011 онд 36.4 сая ам.доллар байснаас 35 хувь өсч 2013 онд 60.4 сая ам.доллар хүрсэн. Хаан банкны чанаргүй зээлийн харьцаа 2013 оны байдлаар 1.5 хувьтай байв. Хаан банкны 54.4 хувийг Савада Холдингс ХХК (өмнө нь Эйч Эс Секүритиз гэдэг байсан) эзэмшдэг. Савада Холдингс ХХК бол Японд байрладаг ба үнэт цаасны арилжаа, банк, зуучлал, үл хөдлөх хөрөнгө, шинээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад хөрөнгө оруулах зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг, Осакагийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компани юм. Хаан банкны 23.0 хувийг Таван Богд Трейд ХХК эзэмшдэг. Таван Богд Групп нь худалдаа үйлчилгээ, аялал хуулчлал, аж үйлдвэрлэл болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 12 охин компани бүхий Монгол Улсын томоохон группуудын нэг юм. Мөн Хаан банкны 13.3 хувийг Д.Хулан, 9.3 хувийг Олон Улсын Санхүүгийн Корпораци тус тус эзэмшдэг.

■ Зорилго ба хүрээ

АХБ-ны туслалцаатайгаар (i) Монгол Улсын бичил, жижиг дунд үйлдвэрүүдийн ДНБ-д оруулах хувь нэмэр нэмэгдэх болон (ii) зээлд хамрагдах боломж нэмэгдэнэ. Уул уурхайн бус салбар дахь бичил, жижиг дунд үйлдвэрүүд хөгжих нь эдийн засгийг төрөлжүүлж, уян хатан байдлыг сайжруулна.

■ Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитай уялдаж буй байдал

АХБ-ны санхүүгийн салбар дахь туслалцааны хөтөлбөрт 2008 онд бие даасан үнэлгээ хийгдсэн. Энэ хүрээнд хийсэн шинжилгээ болон санхүүгийн салбар дахь ирээдүйн сорилт, боломжууд дээр үндэслэн цаашид хийх үйл ажиллагааны зөвлөмж гаргажээ. Үүнд: (i) Монгол дахь банкуудын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэхийн тулд өөрийн хөрөнгийн санхүүжилт, зээл олгох бололцоог судлах, (ii) хөдөө орон нутаг дахь санхүүжилтийн нийлүүлэлтэд байгаа орон зайг нөхөх зорилгоор зээл олгоход банкуудыг ашиглах, (iii) БЖДҮ-ийн хэрэгцээнд нийцэхийн тулд илүү урт хугацааны зээл олгох болон (iv) банк бус болон хөрөнгийн зах зээлийн салбарын хөгжлийг дэмжих зэрэг орно. Иймээс Хаан банкинд олгохоор санал болгож буй тус зээл нь энэхүү үнэлгээнээс гарсан зөвлөмжтэй нийцэж байна.

■ Хөгжлийн үр дүн

—

■ Үр дүн ба хэрэгжүүлэх явц

| | |
|---------------------------------|---|
| Төслийн үр дүнгийн тодорхойлолт | Хэрэгжүүлэх явц, байдал (Үр дүн, үйл ажиллагаа ба асуудал) |
| – | – |
| Хөгжлийн зорилтуудын байдал | Үйл ажиллагаа/барилгын ажлын явц |
| – | – |
| Бодит өөрчлөлт | |
| – | |

■ Бизнесийн боломж

| | |
|--|---|
| Анх жагсаалд оруулсан огноо | – |
| Зөвлөх үйлчилгээ | – |
| Худалдан авах ажиллагаа болон зөвлөх үйлчилгээний мэдэгдэл | |

■ Цаглабар

| | |
|---------------------------------|--------------------------------------|
| Концепцийг батлах | 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр |
| Урьдчилсан судалгаа | 1970 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр |
| Удирдлагаар хэлэлцүүлэх уулзалт | 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр |
| Батлагдсан | – |

■ Төлөвлөсөн график

| Батламжийн дугаар. | Батлагдсан | Гарын үсэг зурсан | Хүчин төгөлдөр болсон | Хаагдах | | |
|--------------------|------------|-------------------|-----------------------|---------|------------|-------|
| | | | | Анхдагч | Шинэчилсэн | Бодит |
| – | – | – | – | – | – | |

■ Холбоо барих ба мэдээллийг шинэчлэхэд

| | |
|---------------------------------|--|
| АХБ-ны хариуцсан Ажилтан | Мониша А. Хэрманс (@adb.org) |
| АХБ-ны хариуцсан Газар | Хувийн хэвшлийн үйл ажиллагаа хариуцсан газар |
| АХБ-ны хариуцсан хэлтэс | Хувийн хэвшлийн санхүүгийн салбарыг хариуцсан хэлтэс |

■ Холбоосууд

| | |
|---|---|
| Төслийн вэбсайт | http://www.adb.org/projects/47934-001/main |
| Төслийн баримт бичгүүдийн жагсаалт | http://www.adb.org/projects/47934-001/documents |
